

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

ХБТББ-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/			Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
							2022				
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ											
4.1. Ногоон хөгжил											
Зорилт 1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.	1	Усны нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор булаг шандны эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулна.	2021-2022	БОАЖГ	БОХНСАХ 10,0 ОНХС, Хувийн хэвшлийн хөрөнгө-14,0	29	10-аас доошгүй булгийн эхийг хашиж хамгаална,	БОХНСА Х 14,0	БОХНСА Х 14,0	-2021-2022 онд орон нутаг болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 13 суманд нийт 62 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцууллаа. -Нарийнтээл сумын Их булаг хэмээх газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах ажлыг усны мэргэжлийн байгууллага “Гидрофонтан” ХХКомпани 2022 оны 6-9 сард гүйцэтгэж хүлээлгэн өгсөн бөгөөд хөв цөөрөм байгуулах ажлын төсөвт өртөг болох 396,8 сая төгрөгийн санхүүжилтийг “Баян тээг” ХК-ний хөрөнгөөр 2023 онд хийлгүүлэхээр төлөвлөж байна.	70
	2	“Дэлгэрэх гол” төслийг үргэлжлүүлнэ.	2021-2022	ЗДТГ, БОАЖГ	БОХНСАХ 494,0	820,0 м газарт шулуутгасан	1000 м газарт ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа	-	-	-Дэлгэрэх голын голдрилын төгсгөл хэсэг болох 820.0 м газарт голын голдрилыг шулуутгах ажлыг “Өндөр Сант хайрхан” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Тус ажлын хүрээнд үерээс хамгаалах далан, бетонон доторлогоо, 2 ш үерийн хоолой, бэхэлгээний шүд зэрэг барилга байгууламжийг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн. Дээрх газарт ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор 1000 м газарт хамгаалалтын хашаа барьж, 3 ш сүүдрэвч	100

										байгуулж, 12000 гаруй мод бут, сөөгийг 2,4 га талбайд тарьсан.	
	3	Арвайхээр, Уянга, Хужирт сумдын төвийн газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг хийлгэж, нөөцийн хэмжээг тогтоолгоно.	2021-2023	ЗДТГ, БОАЖГ	3700.0	Хужирт	Уянга сумын төвийн газрын доорх усны эрэл хайгуул	-	-	-Хужирт сумын төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн нөөцийг үнэлэх судалгааны ажлыг “Карст” ХХКомпани гүйцэтгэн сумын төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн нөөцийг үйлдвэрлэлийн В зэргээр 18.0 л/с буюу 1555.2 м3/ хоногоор тогтоогдсон. -Хайрхандулаан сумын хүн амын ундны усны нөөцийг тогтоох ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан зуун” ХХК-иар гүйцэтгүүлж, шинэ сум төслийн хүрээнд 2022 онд Уянга сумын төвийн газрын доорх усны эрэл хайгуулын ажлын тендерийг Барилга, хот байгуулалтын яамнаас зарлагдаж “Аум алт” ХХК шалгарсан. -Арвайхээр сумын төвийн газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг 2023 онд хийлгэхээр БОАЖЯам, Усны газарт санал хүргүүлээд байна.	70
	4	Бат-Өлзий сумын Хуст, Тарагт сумын Хүрэмт, Баруубаян-Улаан сумын Хүрэн хадны рашааны нөөц, физик-химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.	2022	БОАЖГ, ОТГСГЗ		-	5 сумын 10 рашаан төст булгийг шинжилгээнд хамруулах	15,0	15,0	Орон нутгийн чанартай бүрэн судлагдаагүй Бат-Өлзий сумын Хуст, Ар хятруун, Могойт, Үүртийн тохой, Баруунбаян-Улаан сумын Хүрэн хад, Уянга сумын Өвөр хятруун, Тарагт сумын Хүрэмт, Эмт, Арвайхээр сумын Дэлгэрэх, Бурхи зэрэг рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 оны 06-09 сарын хугацаанд МУ-ын усны чанарын зөвлөх инженер, гидрохимич Ч.Жавзан доктороор ахлуулсан судалгааны багаар гүйцэтгүүлж микробиологи, бичил элементийн 86 үзүүлэлтээр нарийн тодорхойлуулж, тайланг хүлээн авч ИТХ-д танилцуулсан.	100
	5	Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулан, улсын тусгай хамгаалалтад авах саналыг	2021, 2023	БОАЖГ, ОТГСГЗ	-	6560 га	Онги, Таац голын урсац бүрэлдэх эх улсын тусгай хамгаалалтад авах	-	-	-Өлзийт сумын Сангийн далай орчмын 6560 га талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/05 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталсан. -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хүнс, Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хорооны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр	90

		салбарын яаманд тавьж, Сангийн далайг аймгийн тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалтад байх газрын тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.								төгсгөл хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах саналыг хэлэлцүүлж, Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэмжсэн санал ирүүлээгүй тул дахин хэлэлцүүлэхээр хойшлуулаад байна.	
	6	"Орхон-Онги" эко төслийг салбарын яамтай хамтран хэрэгжүүлнэ.	2022-2024	БОАЖГ, ОТГСГЗ	-	Зураг төсөв	-	-	-	Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой "Орхон-Онги" эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Тус төслийн ТЭЗҮ-ийг "Гидродизайн прожект" ХХК, "Престиж инженеринг" ХХК, "Монхидро констракшн" ХХК, "Жемр" ХХК-иуд хамтран гүйцэтгэсэн. "Орхон-Онги" эко төслийн зураг төсвийн үнэ болох 6,8 тэрбум төгрөгийг 2023 оны төсөвт тусгуулахаар БОАЖЯаманд санал хүргүүлсэн.	30
Зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах	1	Арвайхээр хотын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг 50 хувь бууруулна.	2020-2024	АЗДТГ, Арвайхээр сумын ЗДТГ, Баянтээг түлш ХХК, БОАЖГа зар, МХГ	ОНТ-400,0 УТ-2,500,0	-	Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг шахмал түлшээр хангасан байна.	УТ-2,1 тэрбум ОНТ-829,0	УТ-2,1 тэрбум ОНТ-100,0	-Арвайхээр хотын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд 2021 онд "Баянтээг түлш" ОНӨХХК-нь нийт 462 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2-р багийн 300-400 айл өрхийн хэрэглээнд нэвтрүүлэн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор 508 өрхөд угаар мэдрэгч төхөөрөмж суурилуулсан. "Баянтээг түлш" ОНӨХХК-нь 2022 онд 380 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2-р багийн гэр хорооллын 500 айл өрхүүдийг шахмал түлшээр ханган ажиллаж байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөний дагуу шахмал түлш нөөцлөх агуулахын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Шоо констракшн" ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 70 хувь, үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалтын төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Блейз тек" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэл 40 хувь, 1000	70

нөхцөлийг бүрдүүлнэ.										ширхэг мэдээлэл дамжуулах угаар мэдрэгч төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Интелгент технологи" ХХК-тай гэрээ байгуулж ажлын гүйцэтгэл 100 хувь тус тус хийгдээд байна.	
	2	Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэн аж ахуй нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2020-2024	Сумдын ЗДТГ, БОАЖГ, Хувийн хэвшил	-	0.2	1.0	-	-	<p>-Аймгийн хэмжээнд "Бүх нийтийн цэвэрлэгээ"-ний ажлыг улирал бүр зохион байгуулж, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 3823,7 тонн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан. Мөн Хужирт, Баян-Өндөр, Уянга, Богд, Хайрхандулаан, Гучин-Ус, Төгрөг, Өлзийт, Есөнзүйл сумдууд төвлөрсөн хогийн цэгээ хашаажуулж, талбайн хэмжээг багасгах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд нэвтрүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх зориулалтын техник, тоног төхөөрөмжийг сумдад нэвтрүүлэх ажлын хүрээнд Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга сумдууд пресслэгч төхөөрөмж худалдан авч дахивар хүлээн авах цэг бий болгосноор хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломж бүрдэж ангилан ялгасан, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг "Эко цэнэ", Цэмцгэр төвүүдэд хүлээлгэн өгч байна.</p> <p>-Хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг "Өнгө нэм" ТББ-тай гэрээ байгуулж, хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий хогийн савны жишиг загварыг бий болгох, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах, хог хаягдлын чиглэлээр сургагч багш бэлтгэх зэрэг ажлууд хийгдэж байна.</p> <p>-"Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд "Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө"-г Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02</p>	90

										<p>дугаар сарын 25-ны өдрийн 09/09 дүгээр тогтоолоор батлуулан Арвайхээр суманд 1 пүү хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж "Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-т хүлээлгэж өгсөн.</p> <p>-Байгаль орчин, аялал жуулчлалын газраас эко клубын хүүхдүүдтэй хамтран "Цэвэрхэн наадацгаая" нөлөөллийн ажил, усны сан бүхий газар түүний хамгаалалтын бүс, түүний орчмын газрын хог хаягдлыг бүрэн цэвэрлэх ажлын хүрээнд Онги, Дайргын голын дагуух 30 га газрын 13 тн хог хаягдлыг цэвэрлэж, 2 тн дахивар хог хаягдлыг ангилж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт хүргэж, Уянга сумын нутагт орших "Хүйсийн Найман нуур", "Ногоон нуур" орчмын 1,3 тн хог хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлыг Онги Таац голын сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүллээ.</p> <p>-Арвайхээр суманд хог хаягдал ангилан ялгах зориулалт бүхий 150 ш хогийн савыг нийтийн эзэмшлийн зам талбай болон, сургууль, орон сууцны гадна байршуулж, ангилан ялгасан хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын бага оврын тээврийн машинтай болсноор эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажил хийгдэж байна.</p> <p>-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах чиглэлээр төрөл бүрийн сургалт, сурталчилгаа, постер, видео шторк, бэлтгэж цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд олон нийтэд сурталчилж ажилласан.</p>	
	3	Арвайхээр суманд хог хаягдлыг дахин боловсруулах бага оврын үйлдвэр, сумдад цех байгуулж, зарим сумдыг бохир соруулах автомашинаар хангана.	2020-2024	Сумдын ЗДТГ, Тохижилт үйлчилгээний газрууд	2021 онд БОХНСАХ Зардлаас 54,0 сая	1 үйлдвэр, 6 суманд 9 пресслэгч төхөөрөмж	12 сум өөрийн хөрөнгөөр пресслэгч төхөөрөмжтэй болсон байна.	ОНТ 44.0	ОНТ 44.0	<p>-"Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГГазар 2021 оны 10 дугаар сараас эхлэн "Хаягдал хуванцар дахин боловсруулах" үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. БОАЖГазраас үйлдвэрийг дэмжин 2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хоёрдогч түүхий эд боловсруулж хийсэн хашааны шон нийлүүлэх ажилд 18,0 сая төгрөгний санхүүжилт олгосон.</p>	100

										<p>-2021 онд БОХНСАХ-ний 36,0 сая төгрөгийн санхүүжилтээр Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Богд 4 суманд хоёрдогч түүхий эд пресслэгч төхөөрөмжтэй болгосон.</p> <p>-2022 онд Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга сумдууд орон нутгийн төсвөөр пресслэгч төхөөрөмж худалдан авч, Уянга, Хужирт, Богд сумдууд орон нутгийн төсвийн хөрөнгөөр бохир соруулах автомашинтай болсон байна.</p>		
	4	<p>Гэр хороолол, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд дэвшилтэт технологи бүхий “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.</p>	2020-2024	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, Онги-Ус суваг ОНӨААТ ҮГазар, хувийн хэвшлүүд	БОХНСАХ 8,9	<p>2021 онд усан сан бүхий газрын хамгаалалтын бүс 3 ширхэг ариун цэврийн байгууламж байршуулсан.</p>	Аялал жуулчлалын эвэнт арга хэмжээнд зориулж зөөврийн эко АЦБ-тай болох	38.0	38.0	<p>-Азийн хөгжийн банк болон орон нутгийн төсвийн 480.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2019-2020 онд “КА-9100-МОН” төслийн хүрээнд Арвайхээр сумын 13 багийн 283 өрх тус төсөлд хамрагдаж сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. Аймгийн хэмжээнд нийт 29 жуулчны бааз сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болж, Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газрын Найман нуур, Ширээт нуурын эрэгт байгуулагдсан отголох цэгүүдэд 4 ш сайжруулсан ариун цэврийн байгууламж байгуулсан.</p> <p>-Аймгийн хэмжээнд 2020-2022 онд 358 айл өрх өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих ариун цэврийн байгууламжтай болсон байна.</p> <p>-2021 онд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болох Онги, Дайргын голын орчимд 2021 онд хөрсөнд үл нэвчих 3 ш ариун цэврийн байгууламж, хог хуримтлуулах бункерыг байгуулж, ашиглалтад оруулсан.</p> <p>-2022 онд аялал жуулчлалын эвэнт арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламжтай болсон.</p>	90	
	5	<p>Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын</p>	2020-2024	Аймгийн ЗДТГ, БОАЖГ	БОХНСАХ 25.0		<p>- Шаардлагатай бүс нутгуудад биотехникийн ажлыг зохион байгуулсан байна.</p>		10.0	9.0	<p>Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн 2018-2022 оны төлөвлөгөөг 2018 онд “Аргаль, агнуур судлалын төв” ТББайгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд хугацаа дуусч байгаа тул 2023 онд шинэчилж хийлгүүлэхээр төлөвлөөд байна.</p> <p>-Аймгийн байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгааны ажлыг 2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний</p>	100

		менежментийг сайжруулна.								зардлаар ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээр гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан. Судалгааны үр дүнд 61 овгийн 238 төрлийн 517 зүйл ургамал бүртгэгдэж, нэн ховор ургамлын 12 овгийн 13 зүйл ургамлын 48 тархцын цэг, ховор ургамлын 17 овгийн 31 зүйл ургамал, эмийн болон хүнсний ашиглалтад өртөж буй 111 зүйл ургамлын 1059 тархацын цэгийг тогтоосон. -Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2021-2022 онд нэн ховор, ховор амьтдад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, нийт 15 сумын 122 цэгт 4005 боодол өвс, 10.6 тонн хужир тавьж өгөх ажлыг холбогдох сумдын ЗДТГазар, БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, ТББ-ууд, нөхөрлөлийн гишүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Биотехникийн арга хэмжээнд төрийн байгууллагаас гадна сайн дурын иргэд, "Ховор ан амьтад ба гэрэл зургийн ангуучид" ТББ, "Аргалиа аварья" аян, "Мөнх Ногоон хөтөч" ТББ, "Өвөрхангай УАЗ" клуб, "Приус" клубынхэн тус тус идэвх санаачлага гарган хамтран оролцлоо.	
	6	Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийж, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хуулийн хариуцлага тооцон ажиллана.	2020 2024	БОАЖГ, ААНэгж	-	74 га	100 га	-	-	-Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Баярсголд" ХХК, "Өгөөмөр-Өргөө" ХХК, "АУМ-Алт" ХХК-иуд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн. Үүнд дээрх аж ахуйн нэгжүүд 2021 онд техникийн нөхөн сэргээлтийг 67.49 га, биологийн нөхөн сэргээлтийг 7 га талбайд, 2022 онд техникийн нөхөн сэргээлтийг 55.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 10.5 га талбайд буюу нийт 140.49 га талбайд хийж аймаг, сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. -Шүүхийн шийдвэрийн дагуу хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэдээс төвлөрүүлсэн байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлаар Уянга сумын Бөөрөлжүүтийн голд нөхөн сэргээлт хийх сонгон шалгаруулалтад "АУМ-Алт" ХХК шалгарч нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан гэрээний дагуу	90

										<p>2021 онд 9.2 га талбайд нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэсэн. Мөн бусад хууль бусаар үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардал төлөхөөр болсон иргэдээс авах төлбөрийг барагдуулж, нөхөн сэргээлт хийлгэхээр аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж байна.</p> <p>-Гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 81.29 га газрыг нөхөн сэргээх зорилгоор бичил уурхайн зориулалтаар аймгийн ИТХурлын 2022 оны 04 сарын 12-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан.</p>	
	7	<p>Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	2020-2024	<p>БОАЖГ Хэвлэл мэдээллийн байгууллууд</p>	<p>БОХНСАХ 10.0</p>		<p>Аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгааны ажил хийж, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулан, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаудтай хамтран ажилласан байна.</p>	10.0	8.0	<p>-Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор орон нутгийн "Соёмбо" болон МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн "Оюунана брэнд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 78 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 32 удаагийн мэдээ, 2 сэдвийн сурвалжлага, 2 шторк, шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж байгууллагын пэйу хуудас болон вэйб сайтаар иргэд олон нийтэд хүргэсэн.</p> <p>-Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, I, II, IV, V дугаар сургуулийн 8-12 ангийн сурагчдад Өвөрхангай аймгийн нэн ховор, ховор амьтан ургамлын талаар танин мэдэхүйн сургалтыг зохион байгуулж 500 гаруй сурагчид хамрагдсан.</p> <p>-“Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд аймгийн хэмжээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг шалгаруулах болзолт уралдааныг зарласан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Супер анги” шалгаруулах уралдааныг зохион байгуулж, Арвайхээр сумын лаборатори "Мэргэд" сургуулийн 116 анги, Баян-Өндөр сумын 126 анги, Арвайхээр сумын 5 дугаар сургуулийн 10а анги, Богд сумын 12б анги, Бат-Өлзий сумын 12а</p>	100

										анги хамт олон тэргүүн байруудад тус тус шалгарлаа, -Хүүхэд багачуудад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох, байгаль орчинтой зөв харьцах дадал хэвшүүлэх зорилгоор 26 сургуульд эко клубыг ажиллуулж тэднээр дамжуулан нөлөөллийн ажлууд зохион байгуулж байна. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд “Ан амьтад” гэрэл зургийн үзэсгэлэн, “Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа”, “Тэрбум” мод тарих үндэсний хөдөлгөөний нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулж, байгаль орчны мэдээ мэдээллийг БОАЖГ-ын пэйж хуудас болон https://nature.ov.gov.mn/ сайтаар дамжуулан сурталчиллаа.	
	8	Байгаль орчны салбарын хүний нөөцийг чадавхжуулах урт богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамруулан, ажиллах нөхцөл, материаллаг баазаар хангана.	2020-2024	БОАЖГ	2.5	7 удаа	Сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан байна.	-	-	Төрийн албаны зөвлөлөөс гаргасан “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжийн дагуу төрийн албан хаагчдын сургалтын судалгааг гаргаж, байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллалаа. Тус газраас газрын мэргэжилтнүүд, сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагч чадавхжуулах дотоод сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2022 онд 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон НҮБХХ-ийн “Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга-БИОФИН-2 төсөлтэй хамтран МУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг танилцуулах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Уг сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, аймгийн БОАЖГазар, ГХБХБГазар, Онги-Таац голын сав газрын захиргаа, Төрийн сан, Татварын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд, сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг танхимаар, сумдын ИТХ, Засаг дарга, Төрийн сангийн мэргэжилтнүүд, Татварын байцаагч, Газрын даамал, байгаль хамгаалагчид, Сумын	100

									<p>дундын Ойн анги, ОХБЦГХЗахиргааны албан хаагчдыг цахимаар оролцуулж нийт 118 албан хаагч хамрагдлаа. Дээрх сургалттай хамтатган сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагчдыг чадавхжуулах дотоод сургалтыг зохион байгуулж, төрийн албаны болон салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, авлига түүний хор нөлөөний талаар мэдээлэл өглөө.</p> <p>-2022 онд албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр 25, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7x4x10 арга зүйн цуврал сургалтад албан хаагчдын 60 хувь нь хамрагдаж, магистрын хөтөлбөрт 2, докторантурт 1 мэргэжилтэн суралцаж байна.</p> <p>-2021 онд тус газрын харъяа зарим сумдын байгаль хамгаалагч нарын өвлийн хувцасыг шинэчлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу бараа материал нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгож, цэргийн хувцасны "Бөртэ" ХХК-тай гэрээ байгуулан 9 ширхэг өвлийн хүрэм өмд, малгай захиалж хийлгэсэн. - Албан хаагчдын ажлын байрны нөхцлийг сайжруулах зорилгоор 3 өрөөнд засвар хийж тохижуулан 1 мэргэжилтний компьютерийг шинэчилсэн.</p>	
	9	Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтмолжуулан шаардлагатай цэгт газрын генератор байршуулж, цөлжилт, ган хуурайшилтын эрсдэлийг бууруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	2020-2024	УЦУОШГ			-		<p>УЦУОШТөвийн "Онги Бороо-1" "Онги Бороо-2. Бороо-3" "Онги Бороо-4" экспедицүүд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлж 05 дугаар сарын 11, 05 дугаар сарын 27, 28, 06 дугаар сарын 08, 09, 10, 26, 7 дугаар сарын 04, 08 дугаар сарын 06, 13 хүртэл 11 удаа буюу давхардсан тоогоор 4 экспедиц нийт 15 удаа гарч 41 удаа харвалт үйлдэж 123 гр урвалж үүлэнд цацаж зориудаар нөлөөлөн хур тунадас нэмэгдүүлэн Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийн зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлж ажилласан. Өвөрхангай аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж, зуншлагын таатай нөхцөлийг бий болгох үүднээс орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийг тусгуулан ажилласны үр дүнд цаг агаарт зориудаар нөлөөлөх JFJ-1A борооны</p>	100

										пуужин нийт 54 ш пуужингаас 41 ш пуужинг үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн ажилласан.	
Зорилт 3. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн менежментийг бүрдүүлнэ.	1	Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж, ойжуулалт, төв суурингийн ногоон байгууламжид шаардлагатай тарьц, суулгацаар аймгийн хэрэгцээг бүрэн ханган, ойжуулах ажлыг төсөл хөтөлбөрт хамруулах санаачлага гарган ажиллана.	2021-2024	БОАЖГ Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагууд	БОХНСАХ 24,0	Ойжуулалт 20 га Тарьц Суулгац-327.9 ш	Ойжуулалт, төв суурингийн ногоон байгууламжид шаардлагатай тарьц, суулгацаар аймгийн хэрэгцээг бүрэн хангана.	БОХНСАХ-216,0 сая УТ-90,0	БОХНСАХ-216,0 сая УТ-90,0	<p>-Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагуудыг бодлогоор дэмжих хүрээнд 2021 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газар болон “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн газруудын өргөтгөл тарьц суулгац худалдан авахад зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 24,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.</p> <p>-2022 онд аймгийн нутаг дэвсгэрт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчилж 5 аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 216,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласнаар зөвхөн энэ онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, иргэдийн тоо 12-оор нэмэгдлээ.</p> <p>-2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 10 мод үржүүлгийн газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц суулгац ургуулж байсан бол 2022 оны 10 сарын 01-ний байдлаар 22 мод үржүүлгийн газарт 2,0 саяас доошгүй тарьц суулгац ургуулах боломжтой болж аймгийн хэрэгцээг хангах бүрэн боломжтой боллоо.</p> <p>-2021-2022 онд бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдээр нийт 434,300 мянган ширхэг мод бут таригдсан байна.</p> <p>-2022 онд Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх ойжуулалтын ажлыг дүйцүүлж сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9000 ширхэг модыг тарьсан бөгөөд шинэсний тарьцаар гүйцэтгэх ойжуулалтын ажлыг 10 га талбайд хийсэн.</p> <p>-Улсын төсвөөр гүйцэтгэх “Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг “Их сумт хайрхан” ХХК хийж гүйцэтгэлээ.</p>	100

										-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн зорилтот жилийн хүрээнд Арвайхээр, Хархорин, Хужирт сумдад авто зам дагуу 3 км газарт хамгаалалтын ойн зурвас байгууллаа.	
2	Ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, унанги мод цэвэрлэх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн одоогийн байгаа түвшинг тогтвортой хадгалах нөхцөл бүрдүүлнэ.	2021-2024	БОАЖГ, Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгуулл агууд	БОХНСАХ 15,0	1800 га талбайд хортон устгал хийгдсэн байна.	2500 га-д Хортон устгал хийгдсэн байх	БОХНСАХ 86,0	86,0	-2021 онд ой цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх ажлыг хавар, намар 5 удаа зохион байгуулж, нийт 290 га талбайд ой цэвэрлэгээний ажил хийгдэж, хэрэглээний мод 5691 шоо метр, түлээний мод 20958, нийт 26415 шоо метр мод бэлтгэж ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 169618.9 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн бөгөөд орон нутгийн төсвөөр гүйцэтгэх 20 га ойжуулалтын ажлыг “Их сумт хайрхан”, “Өгөөмөр шунхлай” ХХК-иуд Бат-Өлзий сумын Хойд агуйтад хийж гүйцэтгэсэн. Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт сумдын ойгоос мод бэлтгэсэн 9 аж ахуйн нэгж, 17 нөхөрлөл 20 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажил гүйцэтгэж, Бат-Өлзий сумын нөхөрлөлүүд сумын төвийн ногоон байгууламжид 7 нэр төрлийн 5400 ширхэг мод бут тарьсан байна. -2022 оны жилийн эцсийн байдлаар ой цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх ажил нийт 226 га талбайд хийгдэж хэрэглээний мод 6601 шоо метр, түлээний мод 16446,7 шоо метр, нийт 23048 шоо метр мод бэлтгэж ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 161,784,092 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. -Ой цэвэрлэгээгээр мод бэлтгэх ажилд 11 аж ахуйн нэгж, 12 нөхөрлөл оролцсон. Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд 10 га талбайд ойжуулалт хийж, БОХНСАХэмжээний зардлаар 3800 га талбайд ойн хортон хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажил гүйцэтгэлээ.	100	
3	Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Арвайхээр хотын ногоон байгууламжийн хэмжээг 50	2021-2024	Сумдын ЗДТГ, БОАЖГ	БОХНСАХ 25,0				БОХНСА	-Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021-2022 онд аймгийн хэмжээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдээр нийт 430 гаруй мянган ширхэг мод, бут тарьсан бөгөөд нийт тарьсан модны 60 хувь нийтийн эзэмшлийн талбайд, 40 хувь нь аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдэд таригдсан байна.		

		хувь нэмэгдүүлнэ.				Арвайхээр сумын Нийтийн эзэмшлийн талбайд тарих Тарьц суулгац нийлүүлэх	19 суманд 1000-с Доошгүй тарьц нийлүүлсэн байх	БОХНСА 135,6 Зорилтот Жилийн Зардал-	135,6 ОНХС 800,0 Зорилтот жилийн зардал 400,0 ОНТ 1,0 Тэрбум	-Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг улс, орон нутгийн төсөв, айл өрх, албан байууллага, хувийн хэвшлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд 2021-2022 онд сумдын ОНХөгжлийн сангаас 800.0 орчим сая төгрөг, зорилтот жилийн хүрээнд 400,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,0 тэрбум төгрөг, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 135,6 сая төгрөг нийт 2,3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Арвайхээр суманд "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд 12 га цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, төв авто замын дагуу 1.5 км урт ойн зурвас байгуулагдлаа. -Аймгийн хэмжээгээр төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оны суурь түвшингээс 30 га талбайгаар нэмэгдэж 2020 оны суурь түвшингээс 45 га-р нэмэгдэж нийт 185 га болж нэмэгдсэн бөгөөд Арвайхээр сумын ногоон байгууламж 21 га талбайгаар нэмэгдэх боломжтой боллоо.	100
4.2.Аялал жуулчлал											
Зорилт 1. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1	Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан аялал жуулчлалын цогц арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аймгийн аялал жуулчлалын цахим мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.	2021-2024	БОАЖГ	ОНТ 15,0		6 эвент арга хэмжээ	ОНТ 65,0	ОНТ 15,0	-Аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан жил бүр тогтмол зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. 2021 онд ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/89 дүгээр тушаалаар аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд цуцлагдаж оны сүүлчээр буюу 2021 оны 12 дугаар сард "KHARAKHORUM ICE FESTIVAL-2021" мөсөнд авиралтын цомын аварга шалгаруулах тэмцээнийг "Монголиа Экспедишнс" ХХК-тай хамтран 9 дэх жилдээ Бат-Өлзий сумын Улаан цутгаланд зохион байгуулж, 12 байгууллага, клубын 70 тамирчин оролцож, 500 гаруй аялагч ирж сонирхсон бөгөөд дотоодын аялагчдын тоо өмнөх жилүүдээс нэмэгдсэн. -Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хужирт сумын Засаг даргын Тамгын газар, Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн "Дэлхийн өв-Орхон голын нүүдэлчид" аялал жуулчлалын холбоо хамтран бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын эвент	100

										<p>арга хэмжээ “МОНГОЛ ЭСГИЙ УРЛАЛЫН БАЯР”-ыг Хужирт суманд 7 сарын 22-ны өдөр, “САРЛАГИЙН БАЯР”-ыг Бат-Өлзий суманд 2022 оны 07 сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулж, уг эвент арга хэмжээнд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Баттулга оролцсон. Эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор Франц, Польш, Герман, Япон, Швейцар зэрэг орны жуулчид, дотоодын аялагчид нийт 1000 гаруй жуулчид үзэж сонирхлоо. БОАЖЯам Солонгос улстай аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах хүрээнд Солонгосын үндэсний EBS телевизийн “Дэлхийгээр аялцаа” нэвтрүүлгийн багийнхан манай аймагт дээрх эвентүүдийн үеэр ажиллаж 2 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэн Солонгос улсад аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ сурталчлах ажил хийгдэж байна.</p> <p>-Аймгийн аялал жуулчлалын цахим мэдээллийн сан бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах гар утасны аппликейшныг 2021 оны 12 сард ашиглалтад оруулж, 2022 оны 09 сарын байдлаар 612 иргэн хэрэглэж мэдээлэл авсан байна.</p>	
	2	Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулах, байгальд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих бодлого хэрэгжүүлж, Монгол Улсын төв цэгийн “Гал голомт цогцолбор” төсөл хэрэгжүүлж эхэлнэ.	2022-2024	БОАЖГ	-	-	Жуулчдын тоо нэмэгдсэн байх.	-	-	<p>-Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулах ажлын хүрээнд Германы сэргээн босголтын банкны KfW төслийн санхүүжилтээр мэдээллийн самбар, ширээ сандал, хогийн сав тус бүр 3 ш соруулдаг ариун цэврийн байгууламж байршуулж, аялагчдын тав тухтай аялах нөхцлийг сайжруулсан.</p> <p>-Орхоны хөндийн тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд “Орхоны хөндийн тусгай хамгаалалттай газар нутгийн хог хаягдлын менежментийг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг Хужирт суманд 2022 оны 04 сарын 04-нд зохион байгуулж, тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл 60 гаруй иргэд оролцсон. Уг хэлэлцүүлгээс зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн хэмнэлтийн</p>	50

										тухай хуулийн холбогдох заалтын дагуу төсөл цаашид хэрэгжих боломжгүй болсон.	
	3	Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулна.	2021	ХОХБТХ, БОАЖГ, Хархорин сумын ЗДТГазар	1.6 тэрбум		Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж бий болсон байна.	2,8 тэрбум	2,8 тэрбум	Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах 4 багц ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар “Цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээ, бохирын цооног” хийх багц ажлын хүрээнд 520 метр цэвэр усны шугам, 180 метр бохир усны шугам татах ажил, “Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг” багц ажлаас 1500 метр агаарын шугам татаж, 04 кв-ийн дэд станцыг байршуулах, “Явган зам, гадна хайс, сүүдрэвч” багцын хүрээнд 1100 метр хайсан хашаа, явган замын газар шорооны ажил тус тус хийгдээд байна. “Авто зогсоол, эко хавтан” багц ажлын хүрээнд 2 зогсоол баригдсан байна. ХОХБТХ-ээс мэдээлэл нэмж бичих	70
	4	“Хархорин XIII зуун” төсөл хэрэгжүүлж, эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг ил музей болгоно.	2021	ДӨСДГХЗ			Үзмэрийн тоог нэмэгдүүлсэн байна	-	-	“Дэлхийн өв” соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа төсөл хэрэгжүүлж, эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг хамгаалах хашааг барих ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 70.0 сая төгрөгөөр хашаажуулах ажлыг хийсэн.	50
	5	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Өндөр гэгээн Г.Занбазарын үйл хэргийг мөнхжүүлэх цогцолбор төвийг байгуулж эхэлнэ.	2023-2024	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөрийн хөрөнгө	-		Жуулчдын тоо нэмэгдсэн байх.	-	-	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1, 13.3.2 дах заалтын дагуу хэрэгжих боломжгүй болсон.	
	6	Зарим иргэдийг хөтөч, угтах үйлчилгээний сургалтад хамруулж, нутгийн онцлогтой	2021-2024	ХОХБТХ, БОАЖГ	-		Жуулчдын тоо 65103-д хүрсэн байна.			-2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан аялал жуулчлалын зочлох үйлчилгээний цахим сургалтад тус аймгаас жуулчны бааз, зочид буудлын менежер, удирдлагын сургалтад 15, хөтөчийн сургалтанд 12, зочин хүлээн авагч, зөөгчийн сургалтад 8 иргэн тус тус хамрагдаж, “Нореса” сургалтын	100

		аялал жуулчлалыг хөгжүүлэн, бүтээгдэхүүн, үйлчилгээний, чанар, стандартыг сайжруулан жуулчдын тоог суурь түвшингээс 50 хувиар нэмэгдүүлнэ.								төвтэй хамтран зохион байгуулсан аялал “Ковидын дараах сэргээн босголт” сэдэвт сургалтад Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр сумдын нийт 50 гаруй аж ахуйн нэгж, төрийн байгуулагуудын төлөөлөл хамрагдсан. -2022 онд аймгийн Политехникийн коллежтой хамтран аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа нутгийн иргэдийг чадавхжуулах сургалтыг Бат-өлзий суманд зохион байгуулж, зочид буудлын үйлчилгээний ажилтны ангид 28 иргэн, аяллын хөтөчийн ангид 22 иргэн тус тус хамрагдлаа. “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт аймгийн зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, аймгийн хэмжээнд аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл оролцлоо. -Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах зорилгоор тохирлын үнэлгээ хийх аймгийн ажлын хэсэг 2022 оны 6 сарын 30-наас 7 сарын 06-ныг дуустал хугацаанд гэст хаус /гэр буудал/, жуулчны баазуудад тохирлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа.	
	7	Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, аялал жуулчлалын эргэлтэд оруулан, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2021-2024	БОАЖГ			Жуулчдын тоо 65103-д хүрсэн байна.	-	-	-Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор “Өвөрхангайд үйлдвэрлэв”, “Хужиртад үйлдвэрлэв”, “Хархоринд үйлдвэрлэв” төвүүд, Сүүн чихрийн үйлдвэр ашиглалтад орж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн 600 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаалагдаж байна. - “Ай Ти Эм-2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулж, тус үзэсгэлэнд аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 аж ахуй нэгж, байгууллага оролцож, өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж, 2023 онд хамтран ажиллах гэрээ хэлэлцээрүүд хийгдсэн.	70

	8	Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулна.	2021-2022	БОАЖГ	-		Жуулчдын тоо 65103-д хүрсэн байна.	-	-	-БОАЖЯам, Герман улсын сэргээн босголтын банк хамтран хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн санхүүжилтээр 2021 онд жуулчдын гол маршрутын дагуу Хархорин сум Орхон гол, Бат-Өлзий сумын Улаан цутгалан, Төвхөн хийд орчимд, мөн Бат-Өлзий сумын Хойд агуйт, Уянга сумын Хүйсийн найман нуур орчимд нийт 5 байршилд отоглох цэгүүдийг шинээр байгуулж, үйл ажиллагаа болон хамгаалалтыг нутгийн иргэд, ОХБЦГХЗ-ны байгаль хамгаалагч нар хариуцан ажиллаж байна. 2021-2022 онд дээрх отоглох цэгүүдээр нийт 5000 гаруй аялагч үйлчлүүлсэн байна.	100
	9	Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	2021-2024	БОАЖГ, аймгийн АЖХолб оомэргэ жлийн холбоо	-		Жуулчдын тоо 65103-д хүрсэн байна.	-	-	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 37 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд баримтлах журам”-ыг шинэчлэн баталсан. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Уянга сумын Хүйсийн найман нуур орчим 16 өрх, Бат-Өлзий сумын Хүрхрээ, Хойд агуйт, Хустай, Төвхөн хийд орчимд 46 өрх, Бүрд сумын Элсэн тасархайд 4 өрх, Богд сумын Сэрвэн хайрханд 1 өрх нийт 67 өрх эко гэр ажиллуулж байгаа бөгөөд морин аяллын хөтчөөр 26 иргэн ажиллаж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад эко гэр ажиллуулж байгаа малчин өрхийн тоо Уянга сумын Хүйсийн найман нуур орчимд 6 өрх, Бат-Өлзий суманд 8 өрхөөр тус тус нэмэгдсэн байна.	90
	10	Аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлнэ. Үүнд: Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут: Элсэн тасархай, Их, бага Монгол уул - Ширээт	2021-2024	БОАЖГ, аймгийн Аялал жуулчлалын холбоо	-		Жуулчдын тоо 65103-д хүрсэн байна.			-Аймгийн аялал жуулчлалын батлагдсан маршрутын дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд “Монгол эсгий урлалын баяр”, “Сарлагийн баяр” зэрэг эвентийг зохион байгуулж, дотоод гадаадын 1000 гаруй жуулчин зорин ирж үзсэн. -Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрутаар 2022 оны 3-р улирлын байдлаар нийт 38782 жуулчин аялснаас гадаадын 4000 гаруй жуулчин, тусгай сонирхлын аяллын маршрут Уянга сумын Хүйсийн Найман нуур чиглэлд 15000 гаруй жуулчин аялснаас 100 гаруй нь гадаадын жуулчин байна. Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн тоо өмнөх	90

	цагаан нуур - Монгол орны төв цэг, Хархорин-Эрдэнэзуу - Шанхын хийд – Хархорум музей - Хужирт сумын халуун рашаан, Үүртийн тохой - Төвхөн хийд, Улаан цутгалан - Бат-Өлзий сум						38,0	38,0	<p>жилийнхээс жуулчны бааз 1, аж ахуй нэгж 1, малчин өрх 14-өөр тус тус нэмэгдсэн байна.</p> <p>-Говийн болон баруун бүсийн сумдын аяллын маршрутын чиглэлд Баруунбаян-Улаан сумын Хүрэн хадны рашаан, элсний эмчилгээнд нийт 800 гаруй амрагч амарч сувилуулсан байна.</p> <p>-Орхоны хөндийн аяллын гол үзмэр Эртний нийслэл Хархорум хотын түүхийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр “Торгоны зам-Хархорум хот” эрдэм шинжилгээний цахим хурлын илтгэлүүдээр товхимол бэлтгэж 500 ш хэвлүүлсэн.</p> <p>-Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрутын дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэлээр аймгийн Соёл, урлагын газартай хамтран “Занабазар арт” фестивалийг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цуцлагдсан.</p> <p>-Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын батлагдсан маршрутууд бүхий Uvurhangaitravel гар утасны аппликейшныг иргэд олон нийтэд цахим сүлжээгээр сурталчилж ажилласнаар 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 612 иргэн үйлчилгээ авсан байна.</p> <p>-Аялал жуулчлалын гол маршрут дагуу эко ариун цэврийн байгууламжийг байгуулах зорилтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Бат-Өлзий сумын Бага хүрхрээ орчимд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байгуулахаар санал өгсөн.</p>
--	--	--	--	--	--	--	------	------	--

		<p>Таацын цагаан нуур - Өшгөгийн их залаа - Өнц шилүүстэй - Шаргын тасархай, Шаамын рашаан - Хубилай хааны цэргийн хотын туурь. Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут: Элсэн тасархай – Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Өвгөн суварга - Сэрүүн булаг-Сангийн далай – Арвайхээр сумын Өндөр гэгээн Г.Занабазарын цэцэрлэгт хүрээлэн. Зүүнбаян-Улаан сумын аялал жуулчлалын маршрут: Цагаан бургас болон Баянзүрх хайрханы энергийн төв.</p>									
	11	Сум бүрт байгаль, түүх,	2022-2024	БОАЖГ	-			-	-	-Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал	70

		соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн бий болгоно.							<p>жуулчлалын сүлжээ бий болгох зорилгоор, Соёлын өв Хөгжлийн дархлаа” цахим хуудсанд Төгрөг сумын соёлын төв “Ингэ хөөслүүлэх зан үйл”, Бат-Өлзий сумын соёлын төв “Г.Занабазарын бүтээл”, Хайрхандулаан сумын соёлын төв “Суран эдлэл”-ийн өв соёлын контентыг бэлтгэн байршуулсан. Соёлын цаг арга хэмжээ нөлөөллийн аяны хүрээнд Өлзийт, Есөнзүйл, Бүрд сумдын соёлын ажилтнууд “Намрын хит” зохиолын шилдэг дууны тоглолтыг 3 сумын иргэдэд 500 гаруй иргэнд хүргэсэн. Аймгийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан хүүхэд багачуудад зориулан гаргасан “Миний Өвөрхангай” танин мэдэхүйн номонд ан амьтан, байгалийн ургамал, ус, ой, уул уурхай, аялал жуулчлалын талаарх мэдээллүүдийг бэлтгэж оруулан иргэдийн гарт хүргэсэн.</p> <p>-Хужирт суманд зохион байгуулсан “Монгол эсгий урлалын баяр” эвент арга хэмжээний үеэр эсгий уламжлалт аргыг сурталчлах, сайхан монгол хувцастай хос шалгаруулах тэмцээн, дааганы уралдаан, хүүхдийн барилдаан, эсгий урлалын үзэсгэлэн зэргийг зохион байгуулж, “Сарлагийн баяр” эвент арга хэмжээгээр сарлаг бугуйлдах, сарлагийн поло, сарлагийн парад, сарлагийн түүхий эдээр боловсруулсан бүтээгдэхүүний үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.</p> <p>-Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5-р багт “Хужирт Цагаан” ХХКомпани Сүүн чихрийн үйлдвэр нээж, бүтээгдэхүүнээ орон нутагтаа үйлдвэрлэж байна. Үхэр, хонь, ямааны сүүг малчдын гар дээрээс худалдан авч, боловсруулан, сүүн чихэр, бурамтай сүүн чихэр, зөгийн балтай сүүн чихэр, хушгатай сүүн чихэр, чацарганатай сүүн чихэр, резинэн чихэр зэрэг 6 төрлийн чихэр үйлдвэрлэж, өөрийн аймаг төдийгүй улсын хэмжээнд худалдан борлуулж, брэнд бүтээгдэхүүн болж болж чадсан.</p>	
	12	Аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж,	2023-2024	БОАЖГ	-				Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.	30

		хэрэгжүүлж, ажиллана.										
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ											81	